


Why did Jesus Die?



1. Because we are all sinners!

Марк 2:17 Үүнийг сонсоод, Есүс тэдэнд — Эрүүл хүмүүст бус, өвчтэй хүмүүст эмч хэрэгтэй. Би зөвт хүмүүсийг биш, нүгэлтнүүдийг дуудахаар ирсэн юм гэлээ.

Romans 3:10 Энэ нь ингэж бичигдсэнчлэн, «Зөвт хүн алга. Ганц ч алга.

Матай 18:11 Учир нь Хүний Хүү аддагдсаныг аврахаар ирсэн юм

2. Because there is a cost for that sin!

Матай 15:18-20 Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг. Зүрхнээс хорон мүү бодол, аллага, завхайрал, садар самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь гардаг. Эдгээр нь хүнийг бузарладаг. Харин гараа угаалгүй идэх нь хүнийг бузарладаггүй гэжээ.

Romans 6:23 Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.

Марк 16:16 Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй хүн нь яллагдах болно.



There is a cost for sin!

3. Because Jesus died and paid for our sins on the cross!

Матай 1:21 Түүнийг Хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлэв.

Romans 5:8 Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм.

John 3:16 Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.

Матай 18:11 Учир нь Хүний Хүү аддагдсаныг аврахаар ирсэн юм

IV Та үүнийг зөвхөн Бурханы энэрэл, өршөөлийн дагуу итгэлээрээ хүлээн авах боломжтой.

Acts 4:12 Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв.

Ефес 2:8-9 Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.

Titus 3:5 тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин Өөрийнхөө өршөөлийн дагуу шинэтгэлийн угаал ба Ариун Сүнсний сэргээлтээр аварсан юм.

5. хүлээн зөвшөөрвөл таны гэм нүглүүд уучлагдах болно.

Марк 9:23 Есүс түүнд — "Хэрэв Та чаддаг бол" гэв үү? Итгэлтэй хүнд бүх юм боломжтой гэхэд,

Марк 1:15 — Тэр үе биеллээ оллоо. Бурханы хаанчлал ойрхон байна. Гэмшиж, сайн мэдээнд итгэгтүн гэж байлаа.

Марк 10:15 Үнэнээр Би та нарт хэлье. Бурханы хаанчлалыг хүүхэд адил хүлээж аваагүй хэн боловч тэнд орохгүй гэж айлдлаа.

Romans 10:9-10;13 Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ. Учир нь «Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно».



Put your faith in Christ alone!

Та авралд хүрэх Ромын замаар явмаар байна уу? Хэрэв тийм бол Бурханд хандан залбирах энгийн нэгэн залбирал энэ байна. Үүнийг та зүрх сэтгэлээрээ хэлсэнээр Есүс Христэд өөрийн авралыг даатгаж байгаагаа Бурханд илэрхийлж буй хэрэг юм. Энэ залбирлыг хэлсэнээр ч юм уу эсвэл өөр ямар нэгэн залбирал уншсанаар та аврагдахгүй. Зөвхөн бидний гэмийг уучлах чадалтай Есүс Христэд итгэх итгэл л аварч чадах билээ. Энэхүү залбирал нь Бурханд хандан өөрийнхөө итгэлийг илэрхийлэн уучлалыг өгсөнд нь Түүнд талархах энгийн залбирал юм.



“Бурхан минь,

би Таны эсрэг гэм нүглийг үйлдэж, үүнийхээ төлөө шийтгүүлбэл зохистой нэгэн билээ. Гэвч Есүс Христ миний авах ёстой шийтгэлийг үүрч, Түүнд өгсөн итгэлээр дамжуулан би уучлалыг авсан билээ. Би гэм нүглээсээ эргэн, бүх итгэлээ Танаас ирэх авралд тавьж байна. Таны өгсөн гайхамшигт энэрэл болон уучлалд тань баярлалаа! Амээн!”